



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**



Агуулга

1.	Аудитын гэрчилгээ	3
2.	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.8.1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:	7
2.8.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хийсэн аудитын дүнгийн талаар	7
2.8.3	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3.	Менежментийн захидал.....	11
4.	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	13
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	14
4.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17
5.	Хавсралт.....	18
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	18
5.2	Албан шаардлага	25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгж
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.04.25 № 850
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Үүрэг хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.БҮРЭНБАТ



2. Аудитын тайлан

2.1 Оршил

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Ө.Энхтүвшин Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, хөрөнгийн хөдөлгөөн, төсвийн зарцуулалт, авлагын барагдуулалт, дотоод хяналтыг сайжруулах зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1,18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс 2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Д.Энхдалай, аудитор Ц.Цэрэнхүү нар хариуцаж хэрэгжүүлэв.

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн ЗГ-2/239 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан заавар,



аргачлалын дагуу горим, сорилыг гүйцэтгэн үе шатны чанарын хяналтыг хийлгэн, баталгаажуулан баримтжуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад, дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын талаарх ерөнхий мэдээллийг А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Монгол Улсын нутаг дэвсгэрт хүн, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчныг гамшгаас хамгаалах, хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэх, бизнес эрхлэх эрх зүйн таатай орчныг бий болгох, хууль тогтоомж, стандарт хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах, үндэсний үйлдвэрлэл хөгжүүлэхэд стандарт, хэмжил зүй, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын бодлогыг хэрэгжүүлэх, экспорт, импорт, эдийн засгийн өсөлтийг дэмжих гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Шадар сайд Монгол Улсын Засгийн газрын тухай хуулиар гамшиг болон аюулаас хамгаалж, шаардлагатай арга хэмжээ авах, шударга өрсөлдөөнийг зохицуулах, салбарын мэргэжлийн хяналтын болон стандарт, хэмжил зүйн асуудлыг зохион байгуулах зэрэг чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг шуурхай зохион байгуулах;
- Стандарт, хэмжил зүйн асуудлыг хэрэгжүүлэх;
- Шударга өрсөлдөөнийг дэмжих, хянан зохицуулах, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах;
- Салбарын мэргэжлийн хяналтын асуудлыг зохион байгуулах;
- Эдийн засгийн чөлөөт бүсийг хөгжүүлэх;

Шадар сайд нь төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.



Шадар сайдын ажлын албаны удирдлагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, УСНБББОУС, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Шадар сайдын ажлын алба нь Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Э-Тайлан” програм хангамж ашиглаж байгаа ба дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

ЗГХЭГ-ын Дотоод аудитын нэгж нь тайлант онд Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудаас Стандарт, хэмжил зүйн газарт дотоод аудит хийж, 66.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж, холбогдох зөвлөмж өгч ажилласан байна.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2.0 хувиар сонгов.

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн нь 184,654.8 сая төгрөг бөгөөд түүний 2.0 хувь болох 3,693.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн нэгтгэсэн тайлан, балансын дансанд хийсэн эрсдэлийн үнэлгээг үндэслэн материаллаг байдлын түвшинг суурь үзүүлэлтээс 2.0 хувиар тооцсон.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.



Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд ТЕЗ-ийн 1, ТТЗ-ийн 3, ТШЗ-ийн 89 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдэж, аудитад бүрэн хамрагдсан байна.

Хүснэгт 1 (Санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтийн хэлбэр, тоогоор)

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	ТШЗ	73	4	12	-
2	ТТЗ	3	-	-	-
3	ТЕЗ	1	-	-	-
	Дүн	77	4	12	-

Эх сурвалж: Монгол Улсын Ерөнхий аудиторын А/156 дугаар тушаал

Аудитаар 68 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 7 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 1 байгууллагын санхүүгийн тайланд “Сөрөг” санал, дүгнэлт өгсөн байна.

2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 15,616.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2,988.9 сая төгрөгийн 128 зөвлөмж, 2,284.1 сая төгрөгийн 62 албан шаардлага, 88.9 сая төгрөгийн 42 төлбөрийн актыг хүргүүлсэн ба хууль хяналтын байгууллагад 20.6 сая төгрөгийн 3 асуудлыг шилжүүлж, аудитын явцад 10,234.2 сая төгрөгийн алдаа, зөрчлийг барагдуулсан байна.

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт 2 (Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл, сая төгрөгөөр)

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс:							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТШЗ	13	1,128.6	1	5.0	5	370.2	7	753.4	-	-
2	ТТЗ	218	3,918.2	41	83.9	57	1,913.9	117	1,899.8	3	20.6
3	ТЕЗ	4	335.7	-	-	-	-	4	335.7	-	-
	Дүн	235	5,382.5	42	88.9	62	2,284.1	128	2,988.9	3	20.6

Эх сурвалж: 2018 оны санхүүгийн аудитын тайлан

2.8.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хийсэн аудитын дүнгийн талаар

- Стандарт, хэмжил зүйн газар нь жилийн эцсийн бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогыг бүрэн хийгээгүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн, худалдан авсан хөрөнгийг шууд зардлаар бүртгэсэн, батлагдсан төсвийг зориулалтын бус үр ашиггүй зарцуулсан;



- Ховд аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс нь түрээсийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй, анхан шатны баримтын бүрдэлгүйгээр гүйлгээ хийсэн, зохих шийдвэргүйгээр нууцын нэмэгдэл олгосон;
- Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэс нь барилга байгууламж, газрыг дахин үнэлгээнд хамруулаагүй, эд хөрөнгийн жилийн эцсийн тооллого хийгээгүй;
- Говь-Алтай аймгийн Онцгой байдлын газар нь санхүүгийн тайланг алдаатай бэлтгэсэн, төсвийг зориулалт бусаар зарцуулсан, өглөг, авлагыг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтгүй гүйлгээг бүртгэлд тусгасан;
- Хүнсний аюулгүй байдал, үндэсний лавлагаа, лаборатори нь үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөөгүй, худалдан авах төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдаж авсан, шинжилгээний төлбөрийн авлагыг барагдуулаагүй;
- Буянт-Ухаа дахь Хилийн мэргэжлийн хяналтын алба нь үндэслэлгүйгээр орон тоо нэмэгдүүлсэн, ээлжийн амралт тооцохдоо унаа, хоолны мөнгийг дундаж цалинд оруулж тооцсон;
- Дундговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь төсвийн хэмнэлтийн үлдэгдлийг ахмадын санд төвлөрүүлэхдээ хуульд заасан хувь хэмжээнээс илүү төвлөрүүлсэн, ур чадварын нэмэгдлийг үндэслэл муутай олгосон зэрэг зөрчлүүд аудитаар илэрч, дээрх байгууллагуудад “Хязгаарлалттай” санал, дүгнэлт өгсөн,
- Говь-Алтай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэст хийсэн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдэлд түүвэрчилсэн тооллого хийхэд хөрөнгө дутагдсан, анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн, орон тоог хэтрүүлсэн, цалингийн урьдчилгааг суутгаагүй, худалдан авалтыг холбогдох хууль, журмын дагуу явуулаагүй зэрэг зөрчлүүд илэрч, “Сөрөг” санал, дүгнэлт өгсөн байна.

2.8.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Асуудал 1: Балансын данстай холбоотой асуудал

Нэгтгэсэн тайлан дахь үндсэн хөрөнгө, бараа материалыг тулган баталгаажуулах явцад МУЗГ-ын 2015 оны 501 дүгээр тогтоолоор БНХАУ-ын Тяньжины боомт дахь "Улаанбаатар төлөөлөгчийн газар" УТҮГ-ыг татан буулгаж. чиг үүргийг нь "Монголын төмөр зам" ТӨХК-д шилжүүлсэн боловч үндсэн хөрөнгө, бараа материалыг өнөөг хүртэл шилжүүлж өгөөгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн.

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.



2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Шадар сайдын үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулан 136,729.3 сая төгрөгийн төсөв батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлын нийт гүйцэтгэл 124,757.4 сая төгрөг буюу 91.2 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 4,862.4 сая, байр ашиглалтын зардлыг 359.7 сая, хангамж бараа материалын зардлыг 86.9 сая, эм, хоол, нормын хувцасны зардлыг 24.9 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 24.2 сая, бараа ажил, үйлчилгээний бусад зардлыг 167.9 сая, тэтгэмж урамшууллын зардлыг 29.2 сая, албан томилолтын зардлыг 45.5 сая, хөрөнгийн зардлыг 6,615.9 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 244.7 сая төгрөгөөр хэтрүүлснээс шалтгаалжээ.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Шадар сайд Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил, тод мэдээлж байх үүрэгтэй.

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд өөрийн цахим хуудсанд ил, тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч, дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна. Үүнд:

3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, түүний үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт
4. Төсвийн ерөнхийлөн захирагчийн батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэмнэлт, хэтрэлтийн шалтгаан, тайлбарын хамт
5. Улсын төсөвт болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 80.0 хувьтай байна. Энэ нь Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний зарим байгууллагуудын авлага бүрэн барагдаагүйтэй холбоотой байна.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн Х/746 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн болно.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэл болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил



гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Шадар сайдын ажлын албаны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Батлагдсан төсвийг гүйцэтгэлтэй нь харьцуулж шалгахад төсвийг нийт дүнгээр хэтрүүлээгүй боловч зардлын зүйлээр хянагдах зардал буюу бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 244.7 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэл:

Төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх, төсөв хэтрүүлэх, хууль тогтоомж зөрчигдөх,

Зөвлөмж:

Зардлын зүйлээр хянагдах төсвийг хэтрүүлэн зарцуулахгүй байх

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан нар хүлээн зөвшөөрсөн болно.

2. Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь авлагын үлдэгдлийг тулган шалгахад авлага нийт дүнгээрээ буурсан боловч нэгтгэлд хамрагдсан зарим байгууллагын авлага 87.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэл:



Өр, авлагыг барагдуулаагүй байх, өр, авлагыг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байх, нэмэгдсэн байх

Зөвлөмж:

Авлагыг барагдуулах, шаардлагатай гэж үзвэл хууль хяналтын байгууллагад тавьж шийдвэрлүүлэх

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан нар хүлээн зөвшөөрсөн болно.

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 15,616.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 10,234.2 сая төгрөгийн зөрчлийг барагдуулж, зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх 2,988.9 сая төгрөгийн 128 зөвлөмж, 2,284.1 сая төгрөгийн 62 албан шаардлага, төлбөр барагдуулах 88.9 сая төгрөгийн 42 төлбөрийн актыг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.

Эрсдэл:

Дотоод аудитын нэгж төлөвлөгөөнд тусгагдсан аудитыг хийгээгүй байх, дотоод аудит үр нөлөөгүй байх,

Зөвлөмж:

Дотоод аудитын үр нөлөөг сайжруулах, аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангуулах

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан нар хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 09 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Шадар сайдын ажлын албаны удирдлага, санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	108,312,388.5	112,594,076.0
МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,382,205.7	2,770,101.3
АВЛАГА	6,953,251.0	5,725,685.8
УРЬДЧИЛГАА	219,896.5	375,077.5
БАРАА МАТЕРИАЛ	28,930,266.6	30,119,909.1
НӨӨЦИЙН БАРАА	70,301,769.6	72,547,062.4
БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	524,999.1	1,056,240.0
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	181,345,592.4	232,218,720.2
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	181,345,592.4	232,218,720.2
Газар	0.0	454,500.0
Биет хөрөнгө	179,172,600.7	197,429,236.0
Биет бус хөрөнгө	2,172,991.6	34,334,984.3
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	289,657,980.9	344,812,796.2
НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,537,305.9	8,519,095.8
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,373,887.1	6,337,196.6
Өглөг	3,225,773.0	5,964,211.4
Урьдчилж орсон орлого	148,114.1	372,985.2
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,163,418.9	2,181,899.2
Урт хугацаат зээл	1,163,418.9	2,181,899.2
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	285,120,675.0	336,293,700.5
Засгийн газрын хувь оролцоо	285,120,675.0	336,293,700.5
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	91,803,751.7	118,092,383.2
Хуримтлагдсан үр дүн	175,646,151.6	161,090,695.9
